

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, ТАНДАЛТЫН АЛБАНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 11-р сарын 25

Улаанбаатар хот

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр зохион байгуулсан үйл ажиллагаа	1. Хавдрын эсрэг дэлхийн өдөр жил бүрийн 2 сарын 4-ний өдөр болдог бөгөөд энэ өдөр олон нийтийн хавдрын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэхийг дэмжих зорилготой. УХТЭ-ээс иргэдэд зориулсан "Хоол боловсруулах замын эрхтний хавдраас сэргийлье" нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж өнгөрөөлөө. Өдөрлөгөөр 200 гаруй иргэд оролцсон бөгөөд хавдрын эмч, нойр булчирхай, элэг, цөсний мэс заслын эмч, ангиографийн эмч болон эмчилгээний хоол зүйч нараас зөвлөгөө авч иргэдэд эрүүл мэндийн гарын авлага тараагдлаа. Мөн хавдрын эсрэг өдрийн хүрээнд ерөнхий мэс заслын Н.Тайван эмч “Нойр булчирхайн үрэвсэл болон Хавдраар өвчлөх эрсдэл хүчин зүйл” сэдвээр богино видео зөвлөгөөг цахим хуудсанд нийтэлсэн. Зураг 1.1 2. "Бөөр хамгаалах дэлхийн өдөр"-ийн хүрээнд ЕБС-ийн сурагчдад эрүүл мэндийн боловсрол мэдээлэл хүргэсэн. Бөөр, дотоод шүүрэл судлалын тасаг, НЭМ алба Томёо дунд сургуулийн 6-р ангийн сурагчдын дунд “Бөөр хамгаалах 8 дүрэм” сэдэвт сургалтыг орлоо. Энэхүү хичээл нь эрүүл мэндийн болосрол нотолгоонд суурилсан мэдээлэл өгч бөөрний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, зөв дадалд суралцуулах зорилготой юм. Сургалтад 6-р ангийн 30 гаруй сурагч хамрагдсан бөгөөд хүүхдүүд маш идэвхтэй оролцож, олон асуулт асууж бөөрний үүрэг, өвчлөлөөс хэрхэн сэргийлэх талаар сонирхон асуусан сургалт болсон. Мөн Бөөр, дотоод шүүрэл судлалын тасгийн эрхлэгч М.Баясгалан “Бөөрний эрсдэлт өвчлөлөөс сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах нь”,	

		“Шээсний ерөнхий шинжилгээг өгөхдөө юуг анхаарах вэ” сэдэв 2 төрлийн бөөрний эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл видеог эмнэлгийн цахим хуудсанд нийтэлсэн. Зураг 1.2 3. Элгээ хамгаалах дэлхийн өдрийн хүрээнд 3 үйл ажиллагаатай ажил зохон байгуулсан. ➤ Элэгний өвчлөлийн тухай 3 цуврал видео эмнэлгийн цахим хуудсан нийтэлсэн. Үүнд Хоол боловсруулах эрхтэн судлалын тасгаас “Элэгний өвчлөл, вирусийн нөлөө”, Ангиографийн тасгаас “Элэгний хавдрын үеийн Ангиографийн эмчилгээ”, Ерөнхий мэс заслын тасгаас “Элэгний хавдрын оношилгоо мэс засал эмчилгээ” Сэдвээр тус тус цогц мэдээлэл иргэдэд өгсөн. ➤ Элэгний хавдрын эрт илрүүлэг, оношилгоо үзлэгийг 4 сарын 14 - 17 өдрүүдийн хооронд зохион байгуулсан. Үзлэгээр элэгний ЭХО оношилгоо хийж мэс заслын эмч, хоол боловсруулах дотрын эмч, ангиографийн эмч нар болон хоол зүйчийн үзлэг зөвлөгөөг нийт 3 өдрийн турш 800 гаруй иргэдэд хийсэн бөгөөд 15 иргэнийг хавдрын эрт болон сэжигтэй үе дээр оношилон дараагийн шатны тусламж үйлчилгээнд цаг алдалгүй холбож ажилласан. ➤ Элэг хамгаалах дэлхийн өдрийн нээлттэй хаалганы өдөрлөг 4 сарын 18 өдөр зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр элэгний хавдрын үеийн мэс засал эмчилгээний тусламж үйчилгээний төрөл, хагалгаанд хэрэглэгддэг багаж, дурангийн хагалгааны онцлог давуу талыг иргэдэд танилцуулсан болно. Өдөрлөгт нийт 90 орчим иргэд оролцсон. Зураг 1.3 4. Артерийн даралттай тэмцэх өдрийн хүрээнд Зүрх судас судлалын тасгаас 5 сарын 17-ний өдөр Амбулаториор үйлчлүүлж байгаа иргэдийн дунд “Артерийн даралт ихсэх өвчин гэж юу вэ?, Даралтаа хэрхэн зөв хэмжих вэ?, Даралт ихсэлтийн хүндрэлээс хэрхэн сэргийлэх вэ?” гэсэн сэдвүүдээр сургалт явуулсан бөгөөд сургалтанд 68 хүн хамрагдсан. Мөн зүрх судас судлалын тасгаас “Артерийн даралт ихсэлтээс сэргийлэх энгийн алхам”	
--	--	--	--

		3 удаагийн цуврал богино видео зөвлөгөөг эмнэлгийн болон ЭМЯ-ны цахим хуудсанд нийтлүүлсэн. Зураг 1.4 5. "Гепатитгүй ирээдүйн төлөө хамтдаа" уриатай Жил бүрийн 07 дугаар сарын 28-ны өдрийг "Гепатиттай тэмцэх дэлхийн өдөр" болгон тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Энэ өдөр Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвд иргэдийг гепатитын эсрэг дархлаажуулалт, эрт илрүүлэгт хамруулах, мэргэжлийн эмч нарын үзлэг, зөвлөгөөг явуулсан. Өдөрлөгт УХТЭ эмнэлгийн дүрс оношилгооны тасгийн эмч нар, ерөнхий мэс заслын эмч нар хамтран оролцсон нийт 73 иргэнд ЭХО оношилгоог хийж, 95 иргэнд эмчийн зөвлөгөөг хүргэсэн. Зураг 1.5 6. ДЭМБ-аас жил бүр 09-р сарын 17-ны өдрийг үйлчилгээний аюулгүй байдлын талаарх мэдлэг, ур чадвар, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 9-р сарын 17-ны өдрийг дэлхийн нийтээр үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Уг өдрийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албатай хамтран "Нярай болон хүүхэд бүрд аюулгүй тусламж, үйлчилгээ" уриан дор УХТЭ-ийн оношилгооны зааланд 09-р сарын 17-ны өдөр өдөрлөгийг зохион явуулсан. Уг өдөрлөгт 22 тасаг, 3 алба оролцож үйлчлүүлэгчдэд үйл ажиллагаагаа танилцуулан тусламж үйлчилгээ үзүүлэн өдөрлөгийг амжилттай зохион явуулсан. Зураг 1.6 7. Дэлхийн зүрхээ хамгаалах өдрийн хүрээнд оношилгооны төвийн 1 давхарт өдөрлөг зохион явуулж цахим хуудсанд 1 удаагийн рийл, 1 зөвлөмж мэдээллийг бэлтгэн нийтэлж иргэдэд зөвлөгөө мэдээллийг хүргэн дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Зураг 1.7 8. УХТЭ-ийн төв байрны 1 давхарт нүдээ хайрлая өдөрлөгийг зохион явуулж нүдний тасгийнхан иргэдэд хараагаа хамгаалах эрүүл мэндийн энгийн зөвлөгөөг хүргэсэн бол нийгмийн эрүүл мэндийн албанаас постер, брошур нийтлэлүүдийг бэлтгэн хамтран ажиллаа. Зураг 1.8	
--	--	---	--

		9. НҮБ-ийн Хүнс хөдөө аж хуйн байгууллага үүсгэн байгуулагдсан өдөр буюу жил бүрийн 10-р сарын 16-ны өдрийг “Дэлхийн хүнсний өдөр” болгон зарлаж тэмдэглэдэг. Энэ жил “Илүү сайн хүнс, илүү сайн ирээдүйн төлөө гар гараа холбоё” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж УХТЭ-ийн хоол зүйч болон зочин хоол зүйчид, диабетын төвтэй хамтран ҮОЭТ-ийн 1 давхарт өдөрлөгийг зохион явууллаа. Уг өдөрлөгийн бэлтгэл ажлыг хангах буюу постер мэдээллүүдийг бэлтгэн ажиллаа. Мөн уг өдрийн хүрээнд 10-р сарын 14-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран УХТЭ-ийн ажилчдад “Зөв зохистой хооллолт” сэдэвт сургалтыг ҮОЭТ-ийн хурлын зааланд зохион явууллаа. Зураг 1.9 10. "Тархины харвалттай тэмцэх дэлхийн өдөр" жил бүрийн 10 сарын 29 нд болдог бөгөөд энэ өдөр Мэдрэл судлалын тасагтай хамтран ҮОЭТ-д өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан. Энэ жил “Минут бүр амь насны үнэтэй болон Өнөөдөр тархины харвалтын шинжийг таньж суръя, маргааш хэн нэгний амь насыг аваръя” урианд дор нэгдэн 150 гаруй иргэдэд зөвөлгөө өгч, харвалтын эрсдэлийн үнэлгээг хийлээ. Харвалтаас урьдчилан сэргийлэхийн тулд хорт зуршлаа хаях, дасгал хөдөлгөөн тогтмол хийх, өөх тос, давсны хэмжээг багасгах, архи согтууруулах ундаанаас татгалзах зэрэг амьдралын зөв хэв маягт шилжих хэрэгтэй зэрэг зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилласан. Зураг 1.10 11. Жил бүр дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас “Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийг зорилтот уриатай тэмдэглэн өнгөрүүлдэг. Тэгвэл Улсын Хоёрдугаар төв эмнэлэг энэ өдрөөр "Диабетын төв"-ийг байгуулан 11 сарын 12 өдөр нээлтээ хийж уг өдрөөр эмчийн үзлэг, зөвлөгөө мэдээлэл, сургалт сурталчилгааг диабетын төвийнхөнтэй хамтран зохион явууллаа. Мөн мишээл экспо ХКК-ны ажилчдад чихрийн шижингийн үзлэг оношлогоог хамтран зохион явууллаа. Зураг 1.11	
--	--	--	--

		12. Радиологийн дэлхийн өдрийн хүрээнд Дүрс оношилгооны төвтэй хамтран “Дүрс оношилгооны шинжилгээний аргуудыг таниулах” танин мэдэхүйн өдөрлөгийг эмнэлгийн үйлчлүүлэгчид, эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгөөр дүрс оношилгооны төрөл, боломж, ач холбогдлыг таниулах зөвлөгөө мэдээлэл өгч, цацрагийн хамгаалалтын зөв дадал хэвшүүлэх зөвлөмжийг хүргэж, иргэдэд зориулсан зөвлөгөө, мэдээллийн материал тараан ажиллав. Зураг 1.12	
2.	Сургалт сурталчилгаа	1. Оюутны эрүүл мэндийг дэмжих өдрийн хүрээнд шинжлэх ухаан технологийн их сургуулийн Газрын тос өрөмдлөг инженерчлэлийн тэнхимийн I-V-р дамжааны 23 оюутан, 1 багшид нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлж, эрэгтэй, эмэгтэй оюутнуудын эрүүл мэндийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, зөв хэвшил төлөвшүүлэх эрүүл ирээдүйг бий болгоход хувь нэмэр оруулах зорилгоор эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн их эмч Б. Эрдэнэбаатартай хамтран сургалтыг зохион явуулсан. Зураг 2.1 2. “АЖЛЫН БАЙРАН ДАХЬ СЭТГЭЛ ЗҮЙН ЭРҮҮЛ МЭНД” сэдэвт үе шаттай сургалтыг эхлүүллээ. Сургалтыг “Optimal nmax” байгууллагын сэтгэл судлаачидтай хамтран зохион байгуулж байгаа бөгөөд уг сургалтын зорилго нь ажилтнуудын ажлын байран дахь стрессийг бууруулах, сэтгэлзүйн тэнцвэрийг хадгалах, харилцаа хандлагыг сайжруулахад чиглэж байна. Уг сургалтыг постер мэдээлэл болон дүрсжүүлэх, зохион байгуулах үйл ажиллагааг хариуцан ажиллаа. Зураг 2.2 3. Дэлхийн хараагаа хамгаалах өдрийн хүрээнд Монгени цогцолбор сургуулийн 6-р ангийн 120 сурагчдад “Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх, хараагаа хамгаалах” сэдэвт сургалтын Нүд судлалын тасгийн эрхлэгч Д. Батжаргал эмчтэй хамтран зохион явууллаа. Зураг 2.3	

		4. Мон алтиус ахлах сургуулийн 150 сурагчдад эмэгтэйчүүдийн эмч Б. Эрдэнэбаатартай хамтран бэлгийн замаар дамжих халдварт өвчин, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх сургалтыг зохион явууллаа. Зураг 2.4 5. Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан УХТЭ-ийн дэмжих үйчилгээний ажилчдын дунд “Эрүүл зохистой хооллолт” сэдвээр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол зүйн албатай хамтран сургалт явуулсан сургалтанд нийт 72 албан хаагчид хамрагдсан. Зураг 2.5	
3	Зохион байгуулсан, хамтран оролцсон арга хэмжээ	1. Эрүүл мэндийн яамнаас зохион явуулж буй 26 дахь удаагийн “Эрүүл мэндийн технологи-2025”-д оролцох ажлын хэсэг гарган зохион байгуулалтыг хариуцаж ажилласан. Энэ үйл ажиллагааны хүрээнд танилцуулга брошур бэлтгэх, жигдрэлтийн хувцас захиалах баталгаажуулах хариуцах, шаардлагатай зүйлсийг бэлтгэх, рийл мэдээ мэдээлэл бэлтгэх зэрэг бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Манай эмнэлэг 3 өдрийн турш 2 зочин илтгэл, 12 тасгийн эмч сувилагч нарын зөвлөгөө мэдээлэл, үзлэг оношилгоогоор тусламж үйлчилгээгээ үзүүлэн, дэвшилтэт технологио танилцуулан туршлага солилцон, ард иргэдэд зөвлөгөө мэдээл өгч “ШИЛДЭГ ДЭВШИЛТЭТ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” номинацийн эзнээр шалгаран амжилттай оролцсон. Зураг 3.1 2. Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг нь лавлагаа тусламжийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн эмнэлгүүдийн чадамжийг бэхжүүлэх зорилгоор 2022 онд Дорнод, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймаг болон Налайх, Багахангай, Багануур дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллах үйл ажиллагаанд оролцсон. Зураг 3.2 3. УХТЭ-ийн “Эрдмийн чуулган-47” эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулалтанд хамтран ажиллаж арга хэмжээний хэвлэлийн өнгө төрөх дизайн, номны нүүрний загвар, гарын бэлэгний бүрдэл зэрэг бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд нийгмийн эрүүл	

		мэндийн албаараа ажилласан. Мөн эрдэм шинжилгээний хуралд “УХТЭ-ийн үйлчлүүлэгчдийн дундах ХБӨ-ний эрсдлийн үнэлсэн нь” сэдэвт судалгааны ажлаар оролцон Ханий илтгэлийн төрөлд судалгааны ажлыг хэлэлцүүлэн оролцсон. Зураг 3.3	
	Үйлчлэх хүрээний иргэдэд Урьдчилан сэргийлэх үзлэг зохион	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үйчлэх хүрээний иргэдийн бүртгэл мэдээлэлийг гаргаж Гавьяат шагнал, төрийн одонтой иргэд, тэдний ар гэрийн 2500 иргэний бүртгэлийг үүгсэж Амбулаторийн тасаг, тусгай тасагтай хамтран 04 сарын 01 – 08 сарын 01 хүртэл 600 гаруй иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулан ажилласан.	
4.	Цахим хуудас	11-р сарын 20-оос Цахим эрүүл мэндийн булантай болж пүрэв гариг бүрийн 14:30 цагт эмнэлгийн цахим хуудсаар УХТЭ-ийн эмч нараа урьж оролцуулан шууд лайв хэлбэрээр эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийг хүргэн ажиллаж байна. Одоогоор 11,12-р сарын эрүүл мэндийн булангийн төлөвлөгөө гараад хэрэгжээд явж байна. Зураг 4.1 - Эмнэлгийн цахим хуудас хөтлөлтийн дэлгэрэнгүй тайланг хавсралтаар гаргасан болно. Хавсралт 4.2	
5	Сургалт хөгжил	Нийгмийн эрүүл мэндийн албаны мэргэжилтэн Ч.Гүнчинхорлоо нь Бүгд Найрамдах Энэтхэг Ард Улсын Засгийн газрын богино хугацааны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэж Post graduate institute of medical education and research сургуулийн “Нийгмийн эрүүл мэндийн бодлого Менежмент” сургалтанд 9 сарын 2 – 9 хооронд хамрагдаад ирсэн. Зураг 5.1	
Дүгнэлт:		2025 онд Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн Нийгмийн эрүүл мэндийн алба нь олон улсын өдрүүдтэй уялдуулсан урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр цогц, үр дүнтэй үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгуулж ажиллалаа. Нийтлэг дүгнэхэд дараах гол үр дүн гарсан байна. ➤ Олон нийтийн эрүүл мэндийн боловсрол мэдлэг нэмэгдсэн: Хавдар, бөөр, элэг, артерийн даралт, зүрх судас, тархины харвалт, хараа хамгаалах зэрэг өвчлөлийн голлох	


	чиглэлээр 12 гаруй том хэмжээний өдөрлөг зохион байгуулж, 3,000 гаруй иргэнд үзлэг оношилгоо, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн нь эрт илрүүлэг, өвчлөлийн эрсдэлийг бууруулахад чухал нөлөө үзүүлсэн. ➤ Эрт илрүүлэг, оношилгооны үр дүн мэдэгдэхүйц өссөн: Элэгний өвчлөлийн үзлэгт 800 гаруй иргэн хамрагдаж, 15 иргэн хавдрын эрт болон сэжигтэй үе дээр оношлогдон дараагийн шатлалын тусламжид холбогдсон нь нийгмийн эрүүл мэндийн бодит үр дүнг харуулж байна. ➤ Сургалт, танин мэдэхүй түвшин нэмэгдсэн: ЕБС, их дээд сургуулийн 350 гаруй сурагч, оюутанд чиглэсэн сэдэвчилсэн сургалтууд, ажилчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих үе шаттай сургалтууд амжилттай хэрэгжиж, зөв дадал хэвшил төлөвшүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан. ➤ Эмнэлгийн дотоод хөгжил, хамтын ажиллагаа өргөжсөн: Эрүүл мэндийн технологи–2025 арга хэмжээнд амжилттай оролцож, “Шилдэг дэвшилтэт эмнэлгийн тоног төхөөрөмж”-ийн номинацид шалгарсан нь байгууллагын нэр хүндийг бэхжүүлсэн. Мөн аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтвортой өргөжив. ➤ Мэргэжилтний ур чадварын хөгжил сайжирсан: Нийгмийн эрүүл мэндийн албаны мэргэжилтэн Ч.Гүнчинхорлоо нь Энэтхэг улсын тэтгэлэгт хөтөлбөрөөр Нийгмийн эрүүл мэндийн бодлого, менежментийн сургалтад амжилттай хамрагдаж ур чадвараа нэмэгдүүлсэн нь албаны цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой. ➤ Цахим мэдээллийн хүртээмж сайжирсан: Улсын хоёрдугаар төв эмнэлгийн цахим хуудас нь 2025 оны 12-р сарын 03-ны өдрийн байдлаар 56 мянган дагагчидтай ба 2025 оны туршид шинээр 8576 үйлчлүүлэгч цахим хуудсыг шинээр дагасан бол 1075 үйлчлүүлэгч дагахаа больсон байна. 2025 оны 12-р сарын 03-ны өдрийн байдлаар Улсын хоёрдугаар төв эмнэлгийн цахим хуудас нийт 56,464 дагагчтай байна.	
--	---	--

	Жилийн турш: Шинээр дагасан: 8,576 Дагахаа больсон: 1,075 Нийт өсөлт: +7,501 дагагч Оруулсан постер, зөвлөгөөний нийтлэл: 489 Оруулсан бичлэг (рийл, лайв, стори): 99 Хүрэлт (reach): 5,531,661 удаагийн үзэлттэй	
--	--	--


ХАВСРАЛТ:
Зураг 1.1




Зураг 1.2



Зураг 1.3





Зураг 1.4



№2 Артерийн даралт ихсэхээс сэргийлэх энгийн алхам: Эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлье, Таргалалтаас сэргийлье, Эмээ цагтаа ууж хэвшье! 🍏🍏
#Эрүүлзүрх #WorldHypertensionDay



See insights and ads Boost post
👍 265 🗨 41 ➡ 183

УХТЭ-ийн Зүрх судасны их эмч Ч.Давааням
№3 Артерийн даралт ихсэхээс сэргийлэх энгийн алхам: Зөв эмээ, Зөв тунгаар, Тогтсон цагтаа ууж хэвшье! 🍏🍏
#Эрүүлзүрх #WorldHypertensionDay



See insights and ads Boost post
👍 86 🗨 3 ➡ 20

УХТЭ-ийн Зүрх судасны их эмч Б.Отгонтуяа
№1 Артерийн даралт ихсэхээс сэргийлэх энгийн алхам: Даралтаа тогтмол шалга, эмээ цагтаа ууж хэвшье! 🍏🍏
#Эрүүлзүрх #WorldHypertensionDay



See insights and ads Boost post
👍 544 🗨 22 ➡ 214




Зураг 1.6




Зураг 1.7




Э 1




Э 2



Э 3



Э 4



Э 5

Зураг 1.8



Зураг 1.9



Зураг 1.10



Зураг 1.11



Зураг 1.12



Зураг 2.1




Зураг 2.2



Зураг 2.3



Зураг 2.4



Зураг 2.5

Зураг 3.2



Зураг 3.3



Зураг 4.2

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг

LIVE

СЭДЭВ: ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ҮЕД ҮҮСЭХ БОДИСЫН СОЛИЛЦОО БА МЭС ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭ

Б. ОНОН

АУ магистр, мэс заслын тэргүүлэх зэргийн эмч, Ерөнхий мэс заслын эмч

2025.11.20 /Пүрэв гариг/ 14:30 цагт

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг was live.

20 Nov ·

Сэдэв: Чихрийн шижингийн үед үүсэх бодисын солилцооны өөрчлөлт ба мэс заслын э... See more

Boost this post to get more reach for Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг.

Boost post

286 38 128

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг was live.

1d ·

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Цахим эрүүл мэндийн булан мэдээний зочин эмч: А... See more

Boost this post to get more reach for Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг.

Boost post

421 38 272

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг was live.

Published by Teradek · 16h ·

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Цахим эрүүл мэндийн булан мэдээний зочин эмч: Яаралтай тусламжийн тасгийн эмч Ц. Отгонбаяр УГААРЫН ХИЙН ХОРДЛОГЫН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ сэдэвт цахим мэдээлэл.

See insights and ads

Boost post

93 12 comments 33 shares